



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

### Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 6,796,723,177.00 (зургаан тэрбум долоон зуун ерэн зургаан сая долоон зуун хорин гурван мянга нэг зуун далан долоо) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Ховд, Төв, Булган, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх, асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
133000420  
7-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2025 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн  
164/ дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН  
АЙМИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ХАТГААЛТ

| № | Төсөл, арга хэмжээний нэр, байршил                                                                                                       | Төсөл, арга хэмжээний хүчин чадал                                                                                                                                                                                                                                                                             | Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг) | Улсын комиссын акт |               | Бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага                                                      |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|--------------------|---------------|------------------------------------------------------------------------------------------|
|   |                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                               |                                      | Огноо              | Дугаар        |                                                                                          |
| 1 | Ховд аймгийн Алтай сум дахь Эрүүл мэндийн төвийн барилга. (Ховд аймгийн Алтай сум дахь Эрүүл мэндийн төвийн өөрийн эзэмшлийн газар дээр) | Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 15.0м*12.0м, хүзүүвч нь тэнхлэгээрээ 15.0м*4.52м (гадна цахилгаан, дулаан, цэвэр бохир шугам, гадна гэрэлтүүлэг, явган болон авто зам, талбай)                                                                                            | 655,464,031.00                       | 2023.09.14         | ББКД-84-19/23 | Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газар (Ховд аймгийн Алтай сумын Эрүүл мэндийн төв)      |
| 2 | Төв аймгийн Эрдэнэ сум дахь Эрүүл мэндийн төвийн барилга. (Төв аймгийн Эрдэнэ сум дахь Эрүүл мэндийн төвийн өөрийн эзэмшлийн газар дээр) | Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, 15 ортой барилга, зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 27.0м*15.0м, (гадна зам талбай, цэвэр, бохир, холбоо, цахилгаан, дулааны шугам, гадна ариутгах татуурга, гэрэлтүүлэг, халаалт, салхивч, зам талбай, тохижилт, туслах барилга тэнхлэгээрээ 7.2м*10.8м 1 давхар зоорьгүй) | 2,339,788,066.00                     | 2023.11.23         | ББКД-123/2023 | Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар (Төв аймгийн Эрдэнэ сум дахь Эрүүл мэндийн төв)    |
| 3 | Булган аймгийн Орхон сум дахь Эрүүл мэндийн төвийн барилга. (Булган аймгийн Орхон сум, Эрүүл мэндийн төвийн өөрийн эзэмшлийн газар дээр) | Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, дунд төвөгшилтэй, зоорьтой, 2 давхар, тэнхлэгээрээ 18.2м*11.0м (явган зам, инженерийн шугам сүлжээ, гадна тохижилт)                                                                                                                                                        | 2,293,300,000.00                     | 2023.12.12         | 53/2023       | Булган аймгийн Орон нутгийн өмчийн газар, (Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төв) |

| №        | Төсөл, арга хэмжээний нэр, байршил                                                                                                            | Төсөл, арга хэмжээний хүчин чадал                                                                                                                                                                                                 | Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)                                                                                    | Улсын комиссын акт |        | Бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага                                                |
|----------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|--------|------------------------------------------------------------------------------------|
|          |                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                         | Огноо              | Дугаар |                                                                                    |
| 4        | Увс аймгийн Давст сум дахь Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга. (Увс аймгийн Давст сум Эрүүл мэндийн төвийн өөрийн эзэмшлийн газар дээр) | Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, бага ангилалын, өргөтгөлийн барилга, тэнхлэгээрээ 17.0х12.0м8 3 3 давхар, зoorьгүй, 8 ортой (гадна цахилгаан, дулаан, холбооны шугам, гадна бохирын цооног, ариутгах татуурга, гадна тохижилт) | 1,508,171,080.00                                                                                                        | 2023.12.11         | 45     | Увс аймгийн Орон нутгийн өмчийн газар, (Увс аймгийн Давст сумын Эрүүл мэндийн төв) |
| НИЙТ ДҮН |                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                   | 6,796,723,177.00<br>(зургаан тэрбум, долоон зуун ерэн зургаан сая, долоон зуун хорин гурван мянга нэг зуун далан долоо) |                    |        |                                                                                    |